



**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2021 оны 10 сарын 28 өдөр

Дугаар 167

Даланзадгад сум

**Эко жорлон хөтөлбөр батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 “ж”, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, Эрүүл ахуйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 2/4 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Эко жорлон” хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.
2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө гарган, шаардагдах хөрөнгийг жил бүрийн аймгийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгаж, үр дүнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /Р.Сэддорж/-д даалгасугай.
3. Төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн хамтын оролцоонд тулгуурлан хөтөлбөрийг хэрэгжүүлж, үр дүнг нэгтгэн жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг дарга /Р.Сэддорж/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАДРАА

462200935

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2021 оны 10 дугаар сарын 28-ны  
өдрийн 167 дугаар тогтоолын хавсралт



## **“ЭКО ЖОРЛОН” хөтөлбөр /2020-2024/**

### **Нэг. Ерөнхий мэдээлэл**

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.1.4. Гэр хороолол болон аялал жуулчлалын бүсэд “Эко жорлон” арга хэмжээг хэрэгжүүлж, хөрсний бохирдлыг бууруулна гэж заасан.

Мөн Өмнөговь аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны “Нутгийн хишиг” хөтөлбөр “Орчны болон агаарын бохирдлыг бууруулах зорилгоор иргэдийн оролцоотой хөтөлбөр хэрэгжүүлж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх” /хот, суурин газрын агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулж, хог хаягдлын зохистой менежментийг хэрэгжүүлэх/ зорилтыг дэвшүүлж, төвлөрсөн цэвэрлэх байгууламжид холбогдоогүй сум, суурин газарт говийн байгаль цаг уурын нөхцөлд тохирсон “Эко жорлон” хөтөлбөрийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд эхлүүлэх үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр заасныг үндэслэн энэхүү хөтөлбөрийг боловсруулав.

Хаврын болон дулааны улиралд гэдэсний, халдварт шар өвчин дэгдэж байгаагийн гол шалтгаан нь уламжлалт Монгол жорлон болохыг эрүүл мэндийн байгууллагууд анхааруулсаар байна.

Гэр хорооллын айл өрхүүд жорлонгоо сайжруулснаар халдварт өвчнөөс сэргийлэх, амьдрах орчин сайжирч, гэдэсний болон халдварт шар өвчний дэгдэлтийг бууруулах гэх мэт олон эерэг талтай. 2020 оны судалгаагаар 15 сумын хэмжээнд хөдөө болон гэр хорооллын 21106 өрхийн ариун цэврийн байгууламж /нүхэн жорлон/-ийн тоо 18257 буюу 86,5 хувь нь стандартад нийцэхгүй байгаа нь нянгийн болон хөрсний бохирдлын эх үүсвэр болж байна.

Мөн 15 сумын төвд цэвэр, бохир усны шугам, цэвэрлэх байгууламжийг барьж ашиглалтад оруулсан бөгөөд 2021 оны эхний хагас жилийн байдлаар 15 сумын төвд цэвэр усны шугам 194,2км-т тавигдаж 1622 айл өрх холбогдсон бол бохирын шугам 109,6км урт тавигдаж 891 айл өрх холбогдсон байна.

Иймд инженерийн шугамд ойрын хугацаанд холбогдох боломжгүй гэр хорооллын айл өрхүүдэд болон аялал жуулчлалын бүсэд эко жорлон арга хэмжээг хэрэгжүүлж, аялал жуулчлалын бааз болон худалдаа үйлчилгээний байгууллагуудын ариун цэврийн байгууламжийг стандартын шаардлага хангуулж иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн, ойрын хугацаанд үр дүнд хүрэх, бодитой үйл ажиллагааг тодорхойлсон нэгдсэн бодлого боловсруулж, техник, технологи, хөрөнгө санхүү, хүний нөөцийн бүхий л боломжийг ашиглан салбар дундын нэгдсэн зохицуулалтыг ханган хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага гарч байна.

## **Хоёр: Хөтөлбөрийн зорилго, зорилт**

### **2.1. Хөтөлбөрийн зорилго**

Инженерийн шугамд ойрын хугацаанд холбогдох боломжгүй гэр хорооллын айл өрх, сургуулийн дотуур байр, цэцэрлэг, аялал жуулчлалын бүс, худалдаа үйлчилгээний байгууллагуудад эко жорлон /хэрэглэж байгаа хүнийхээ тав тухыг хангасан, агааржуулагчтай, гэрэлтүүлэгтэй, бохирын үнэргүй, нүхэн дэх бохир далдлагдсан, цэвэрлэж арчлах, ариутгахад хялбар, өртөг зардал бага/ арга хэмжээг хэрэгжүүлж хүрээлэн буй орчин, хөрсний бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

### **2.2. Хөтөлбөрийн зорилт**

- 2.2.1. Хот, суурин газрын гэр хороолол аялал жуулчлалын түр буудаллах цэгийн ариун цэврийн байгууламжийг эрүүл ахуйн стандартын шаардлагад нийцүүлэх замаар боловсронгуй болгох; /нүхэн жорлон, бохир усны нүх/ MNS 5924:2015,
- 2.2.2. Аялал жуулчлалын баазууд болон худалдаа үйлчилгээний газрууд, нийтийн эзэмшлийн газрын жорлонг стандартын шаардлагад нийцүүлэх
- 2.2.3. Даланзадгад хотын төв цэвэрлэх байгууламж болон сумдын цэвэрлэх байгууламжуудыг бүрэн ашиглалтад оруулах, засвар үйлчилгээг тогтмолжуулж хүчин чадлыг нэмэгдүүлэх, байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт технологиор шинэчлэх;
- 2.2.4. Орчны болон хөрсний бохирдлыг бууруулахад иргэд, олон нийтийн оролцоо, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж, эрүүл амьдрах зөв дадлыг төлөвшүүлэхэд чиглэсэн нөлөөллийн ажлуудыг үе шаттайгаар зохион байгуулах
- 2.2.5. Стандартын шаардлага хангасан, эко ариун цэврийн байгууламжийг жишиг зураг төсвийн дагуу иргэн өөрийн хөрөнгөөр шинээр барих санал, санаачилгыг дэмжинэ.
- 2.2.6. Хөрс, усыг бохирдуулж байгаа эх үүсвэрийн тооллого явуулж, бүртгэл мэдээллийн сан бүрдүүлж, орчны чанарын хяналт-шинжилгээний чадавхыг бэхжүүлэн судалгаа, шинжилгээний ажлыг өргөжүүлж үр дүнтэй болгох.

### **Гурав: Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, уялдаа**

- 3.1. Хөтөлбөрийг 2020-2024 онд хэрэгжүүлнэ.
- 3.2. Дараах хөтөлбөрүүдтэй уялдаж хэрэгжүүлнэ.
  - 3.2.1. “Агаар, орчны бохирдлыг бууруулах” үндэсний хөтөлбөр
  - 3.2.2. “Агаарын бохирдолгүй Өмнөговь” хөтөлбөр
  - 3.2.3. “Цэгцтэй гэр хороолол” хөтөлбөр
  - 3.2.4. “Эх хүүхдийн эрүүл мэнд” хөтөлбөр

**Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгө, санхүүжилтийн эх үүсвэр**

- 4.1. Хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээ, ажлыг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:
  - 4.1.2. Улсын болон орон нутгийн төсөв;
  - 4.1.3. Олон улсын байгууллага, хандивлагч орны зээл, тусламж;
  - 4.1.4. Аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгө;
  - 4.1.5. Бусад эх үүсвэр.

#### **Тав. Үйл ажиллагааны чиглэл, хүрэх үр дүн**

- 5.1. Хот, суурин газрын гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг эрүүл ахуйн стандартын шаардлагад нийцүүлэх замаар боловсронгуй болгох**
  - 5.1.1. Эко жорлон хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой журам батлуулж, мөрдүүлэх
  - 5.1.2. Ногоон байгууламж бүхий эко жорлон төсөл хэрэгжүүлэх
  - 5.1.3. Айл өрх, аж ахуйн нэгжүүдийг эко жорлон ногоон зээлд хамруулах арга хэмжээг Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай хамтран хэрэгжүүлэх /жилийн 3 хувийн хүүтэй зээл/
  - 5.1.4. Сумдын сургууль цэцэрлэгийн гаднах нийтийн ариун цэврийн байгууламжийг усны нөөц хязгаарлагдмал, хуурай уур амьсгалтай орчинд нийцсэн, дэвшилтэд технологи ашиглан шинэчлэх
- 5.2. Аялал жуулчлалын баазууд болон худалдаа үйлчилгээний газрууд, нийтийн эзэмшлийн газрын жорлонг стандартын шаардлагад нийцүүлэх**
  - 5.2.1. Жуулчинд үйлчилгээ үзүүлэгч Монгол гэрүүдийг бүрэн эко жорлон хөтөлбөрт хамруулах арга хэмжээг зохион байгуулж, үүрэгжүүлэх
  - 5.2.2. Ариун цэврийн байгууламж бүхий жишиг түр буудаллах цэг байгуулах
- 5.3. Даланзадгад хотын төв цэвэрлэх байгууламж болон сумдын цэвэрлэх байгууламжуудыг бүрэн ашиглалтад оруулах, засвар үйлчилгээг тогтмолжуулж хүчин чадлыг нэмэгдүүлэх, байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт технологиор шинэчлэх;**
  - 5.3.1. Сумдын төвийн цэвэрлэх байгууламжийг бүрэн ашиглалтад оруулахад шаардлагатай мэргэжлийн байгууллагын эрх олгох, боловсон хүчинг бэлтгэх, нэмэгдүүлэх
  - 5.3.2. Цэвэрлэх байгууламжуудын техник технологийг шинэчлэх, сайжруулах, хүчин чадлыг нэмэгдүүлэх
  - 5.3.3. Ариутгах татуургын автомашины тоог нэмэгдүүлэх
- 5.4. Орчны болон хөрсний бохирдлыг бууруулахад иргэд, олон нийтийн оролцоо, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж, эрүүл амьдрах зөв дадлыг төлөвшүүлэхэд чиглэсэн нөлөөллийн ажлуудыг үе шаттайгаар зохион байгуулах**
  - 5.4.1. Хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд ээлтэй, хэмнэлттэй, хөрсний бохирдлыг бууруулах, дэвшилтэт технологи бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэгч орон нутгийн иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих бодлого хэрэгжүүлнэ.

5.4.2. Агаар, орчны бохирдлын эх үүсвэр, хор уршиг, сөрөг нөлөөллийн талаар олон нийтэд бодитой мэдээлэл өгч, зөв дадал хэвшилд сургах, иргэний байгаль орчныг хамгаалах журамт үүргийг таниулахад чиглэсэн сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах;

5.4.3. Агаар, орчны бохирдлыг бууруулахад идэвх, санаачилгатай, дэмжиж ажилласан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах, үйл ажиллагааг нь сурталчлах;

**5.5. Хөрс, усыг бохирдуулж байгаа эх үүсвэрийн тооллого явуулж, бүртгэл мэдээллийн сан бүрдүүлж, орчны чанарын хяналт-шинжилгээний чадавхыг бэхжүүлэн судалгаа, шинжилгээний ажлыг өргөжүүлж үр дүнтэй болгох**

5.5.1. Агаар, орчныг бохирдуулж байгаа эх үүсвэр, хаягдлын тооллогыг чанаржуулж, бүртгэл, мэдээллийн цахим санг бүрдүүлэх;

5.5.2. Орчны чанарын хяналт-шинжилгээний багаж, тоног төхөөрөмжийг сайжруулах, шинэчлэх замаар чадавхыг бэхжүүлэн судалгаа, шинжилгээний ажлыг өргөжүүлж үр дүнтэй болгох.

**Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүн**

6.1. Хүн амын суурьшлын орчны агаар, ундны усны чанар, аюулгүй байдлын үзүүлэлт сайжирч, хөрсний бохирдолтын түвшин буурснаар эрүүл, аюулгүй орчин бүрдэж, орчны бохирдлоос үүдэлтэй хүн амын өвчлөл буурна.

6.2. Орчны бохирдлоос хүний эрүүл мэндэд үзүүлж байгаа сөрөг нөлөөллийн талаар олон нийтэд бодит мэдээлэл өгснөөр хүн амын эрүүл мэндийг хамгаалах, хүн амд эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, эрүүл аж төрөх орчныг бүрдүүлэхэд ахиц гарна.

6.3. Салбар дундын болон төрийн бус байгууллага, иргэд, хамт олон, аж ахуйн нэгж, байгууллагын хамтын ажиллагаа сайжирч, үйл ажиллагааны нэгдмэл байдал хангагдана.

6.4. Хүрээлэн байгаа орчны бохирдол, уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалан хүний эрүүл мэнд, эдийн засагт учирч байгаа хор хохирлыг бууруулах чиглэлээр салбар дундын хамтын ажиллагаа өргөжиж, харилцан уялдаа бүхий үйл ажиллагааны нэгдмэл байдал хангагдана.

**Долоо. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төрийн байгууллага болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоо, хүлээх үүрэг**

**7.1. Аймгийн Засаг даргын Тамгын газар**

7.1.1 Хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн аймгийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгаж, төсөвт үе шаттай тусгах

7.1.2 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх асуудлаар олон улсын байгууллага, хандивлагч орнуудтай хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх

7.1.3 Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн санаачлага, оролцоог дэмжих, идэвхжүүлэх

7.1.4 Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх

**7.2. Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар**

- 7.2.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг мэргэжлийн удирдлагаар хангах, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох, хамрагдах хүрээг тогтмолжуулах
- 7.2.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаанд шаардагдах зардал, хөрөнгийг жил бүр төсөвт тусган батлуулах
- 7.2.3. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг нэгтгэн аймгийн ЗДТГазар болон иргэд олон нийтэд жил бүр тайлагнана.

### **7.3. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар**

- 7.3.1. Хөтөлбөрийг сумын хэмжээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Засаг даргын захирамжаар батлан, хэрэгжилтийг зохион байгуулж, сум орон нутгийн хэмжээнд хэрхэн хэрэгжиж буйд хяналт тавих
- 7.3.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлж зөв зохистой зарцуулах
- 7.3.3. Хөтөлбөрийг хэрэгжилтийн явц, үр дүнг аймгийн Засаг даргын Тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газарт хагас болон бүтэн жилээр тайлагнана.

### **7.4. Төрийн бус байгууллагын оролцоо**

- 7.4.1. Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа холбогдох төрийн байгууллагуудтай хамтын ажиллагааны гэрээ байгуулж үр дүнтэй хамтран ажиллах
- 7.4.2. Эко жорлонгийн тоог нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой төсөл, бусад арга хэмжээг бие даан мөн Олон улсын бусад байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх, хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлэх, хяналт тавих, нутгийн иргэдийг оролцуулах
- 7.4.3. Аялал жуулчлалын зорих газрууд, дамжин өнгөрөх сум суурин, аймгийн төвд Японы “Мичи-но-эки” загварын, Орон нутгийн иргэдийн үйлдвэрлэсэн “бренд” бараа бүтээгдэхүүн, худалдаа үйлчилгээг үзүүлэх, байгаль орчин аялал жуулчлалын мэдээлэл өгөх зориулалттай нийтийн бие засах газрыг орон нутгийнхаа байгаль цаг уур, хүн амын тоо, дамжин өнгөрөх урсгалд нийцүүлэн ААН, төр, төрийн бус байгууллагын хамтын оролцоонд тулгуурлан шат дараатайгаар байгуулах
- 7.4.4. Аймаг, сумдад шинээр байгуулагдаж байгаа төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн зочид буудал, амралт сувилал, нийтийн хоолны үйлчилгээний газруудад боловсон бие засах газартай байгуулах шаардлагыг тавьж хэрэгжүүлэх

### **7.5. Аж ахуйн нэгж, байгууллагын оролцоо**

- 7.5.1. Орчны болон хөрсний бохирдлыг бууруулах, эко жорлон хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой төр, захиргаанаас гаргасан бодлого, шийдвэрийг судлах, тэдгээрийг хэрэгжүүлэх ажлыг байгууллагын хэмжээнд зохион байгуулж үр дүнг тооцох
- 7.5.2. Жуулчны баазууд болон шатахуун түгээгүүрийн газар, олон нийтийн үйлчилгээний газрууд стандартын шаардлагад нийцсэн боловсон бие засах газартай болж нүхэн жорлонг бүрэн халсан байна.

7.5.3. Малчид, нөхөрлөл, байгаль хамгаалах клубын гишүүдийн экологийн боловсролыг дээшлүүлэх, эко жорлонгийн стандартыг мөрдөж төсөл боловсруулж хэрэгжүүлэх, нөхөрлөл байгууллагуудын идэвх санаачлагыг дэмжих, хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлэх

#### **7.6. Иргэдийн оролцоо**

7.6.1. Иргэд нь орчны болон хөрсний бохирдол, эрүүл аюулгүй орчин бүрдүүлэхэд гарсан төр, засгийн хууль тогтоомжийг чанд биелүүлж, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавьж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд идэвхтэй оролцох

7.6.2. Эко жорлон хөтөлбөрт хамрагдахад тавигдах шаардлагыг хангаж, тодорхой хэмжээний төсөв хөрөнгийг шийдвэрлэсэн байна.

#### **Найм. Хөтөлбөрийн удирдлага зохион байгуулалт**

8.1. Хөтөлбөрийн үйл ажиллагааны нэгдсэн удирдлага зохицуулалтыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс хариуцаж ажиллана.

8.2. Хөтөлбөрийг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх салбар дундын үйл ажиллагааг зохицуулах, хэрэгжилтэд нь хяналт тавих үүргийг сумдын Засаг даргын Тамгын газар, аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Ус цаг уур, орчны шинжилгээний төв, Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн газар, Гүний ус ХХК, Говь Гурван сайхан Байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа, “Гайхамшигт говь аялал жуулчлалын холбоо” ТББ хамтран гүйцэтгэнэ.

8.3. Хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан ажлын явц, хэрэгжилтийг нэгтгэн, үр дүнг тооцох, тайлагнах ажлыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар, “Гайхамшигт говь аялал жуулчлалын холбоо” гүйцэтгэнэ.

#### **Ес. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ**

9.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээг бүх шатны Засаг дарга, байгаль орчны чиглэлийн байгууллагууд хамтран гүйцэтгэж үр дүн, тайланг аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлнэ.

9.2. Аймгийн Засаг даргын Тамгын газар хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг жил бүрийн эхний улиралд багтаан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулна.

9.3. Хөтөлбөрийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд холбогдох хууль, журамд заасны дагуу нэмэлт, өөрчлөлт оруулж болно.